



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 87/43

Улаанбаатар хот

Шагналд зарцуулагдах
төсвийг гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн баяр наадмын шагналд шаардлагатай төсвийг хавсралтаар батлах, шагналд зарцуулах 150,000 (нэг зуун тавин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Отгонжаргал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн
87/43 дугаар захирамжийн хавсралт



ШАГНАЛД ЗАРЦУУЛАГДАХ
ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Төсвийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
Шагналын дагалдах мөнгө					
1.	Үнэмлэхний хавтас	Ширхэг	30	4,500	135,000
2.	Инк цаас	Боодол	1	15,000	15,000
Нийт					150,000